



БАЯНХОНГОР АЙМАГ
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/49

Хөхбүрд

Г Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан Г
сэргийлэх дархлаажуулалтын ажлыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.12, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр 9.6 дугаар заалт, Монгол Улсын Засгийн газрын "Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчний жагсаалт батлах тухай" 2018 оны 225 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 16 өдрийн А/232 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт дархлаажуулалтын арга хэмжээг 2025 оны 05 дугаар сарын 01-ээс 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл технологит хугацаанд зохион байгуулсугай.

2. Мал, эмнэлгийн ерөнхий газраас баталсан төлөвлөгөөний дагуу малын дархлаажуулалтын ажлыг технологит хугацаанд нь чанартай зохион байгуулахыг Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн үйлчилгээний аж ахуйн нэгжийн эмч нарт даалгасугай.

3. Сумын хэмжээнд дархлаажуулалт ажлыг хийснээс хойш 28 хоногийн хугацаанд тухайн мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг хүнсний зориулалтаар хэрэглэх, зах зээлд гаргаж борлуулах, нөөц бүрдүүлэхийг хориглосугай.

4. Дархлаажуулалтын ажлыг технологит хугацаанд нь чанартай зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч (Ж.Ёндонпил), багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Гансүх)-д даалгасугай.


ДАРГА  Б.БЯМБАДОРЖ



642501005

سنتی شہریتوں

ہیں۔۔۔



رہنمائی

الحکومت

۱- (پنجاب، پاکستان، حکومت) کے لیے ریجنل ایجنسیوں کے لیے

پنجاب، پاکستان، حکومت (پنجاب، پاکستان، حکومت) کے لیے

۲۰۲۳ء کا سال ۰۲

تعمیراتی



پنجاب، پاکستان، حکومت (پنجاب، پاکستان، حکومت) کے لیے

642501005